НУУЦ

*Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын санхүүжилтийн гэрээний "ХАВСРАЛТ В"*

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ" ХК

ИЛ БОЛСОН

# "ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ" ХК

# БОЛОН

# "БОДЬ ИНТЕРНЭШНЛ" ХХК-ИЙН

# ХООРОНД БАЙГУУЛСАН

# НҮҮРС НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

**Дугаар:** ЭТТ-2019/784

**Дугаар:** BI-TTGS-CONT-0003

**2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр**

24 - 49

ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ ХК
ЭТТ JSC

Гүйцэтгэгч

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ

# НҮҮРС НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

| | | |
|---|---|---|
| 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр | Дугаар: ЭТТ-2019/784<br>Дугаар: BI-TTGS-CONT-0003 | Улаанбаатар хот |

НУУЦ CONFIDENTIAL "ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ" ХК

## НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

ИЛ БОЛСОН

1.1. Энэхүү Нүүрс нийлүүлэх гэрээ /цаашид "гэрээ" гэх/-г нэг талаас "Эрдэнэс-Тавантолгой" ХК (регистрийн дугаар: 5435528) (цаашид "Худалдагч" гэх), нөгөө талаас "Бодь интернэшнл" ХХК (регистрийн дугаар: 2040433) (цаашид "Гүйцэтгэгч" гэх) нь:

- Худалдагч нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт байрлах Тавантолгойн нүүрсний ордод хамаарах ашигт малтмалын ашиглалтын MV-011953, MV-011954, MV-011955, MV-011956, MV-016881, MV-016882, MV-016883 дугаартай тусгай зөвшөөрлүүдийн эзэмшигч болохыг тэмдэглэн,

- Худалдагч нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг эзэмшигч "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн 66 /жаран зургаан/ хувийг эзэмшигч болохыг тэмдэглэн,

- Гүйцэтгэгч нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн бүтээн байгуулалтын ажлын зураг төсөл, худалдан авалт, барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгч болохыг тэмдэглэн,

- Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын Техник, эдийн засгийн үндэслэлд заасны дагуу төмөр замын бүтээн байгуулалтын ажлын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажилд нийт 1.068.577.163 /нэг тэрбум жаран найман сая таван зуун далан долоон мянга нэг зуун жаран гурван/ ам.доллар шаардлагатай бөгөөд үүнээс энэхүү гэрээ байгуулагдахаас өмнө "Монголын төмөр зам" ХХК-ийн захиалгаар гуравдагч этгээд 276.377.656 /хоёр зуун далан зургаан сая гурван зуун далан долоон мянга зургаан зуун тавин зургаан/ ам.долларын ажил гүйцэтгэсэн болохыг тэмдэглэн,

- Худалдагч нь "Эрдэнэс-Тавантолгой" ХК, "Тавантолгой төмөр зам" ХХК, Гүйцэтгэгч нарын хооронд 2019 оны 10 дугаар сарын 29 -ний өдөр байгуулагдсан "Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын санхүүжилтийн гэрээ"-ний дагуу төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхэд шаардагдах 110.0 /нэг зуун арав/



TAVAN ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХК ERDENES TOLGOI УЛААНБААТАР ХОТ JSC

Гүйцэтгэгч



ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ" ХК
ИЛ БОЛСОН

сая ам.долларын урьдчилгаа төлбөрийг мөнгөн хөрөнгөөр төлөхөөр тохиролцсон болохыг дурдан,

- Монгол Улсын Иргэний хууль, Төмөр замын тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Компанийн тухай хуулиудын холбогдох хэсэг, Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоол, 2018 оны 73 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны 304 дүгээр тогтоол болон холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэл болгон,

- Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн хамтарсан А/184, 284, А/239 дүгээр тушаал болон Тагнуулын ерөнхий газрын 2019 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 01/1208 болон мөн оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 01/1270 дугаартай албан бичгээр ирүүлсэн дүгнэлт, зөвлөмжийг тус тус үндэслэн,

- "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн "Их хэмжээний хэлцэл" хийх зөвшөөрөл олгох тухай 56-р тогтоолыг үндэслэн,

Талууд тус тусын амлалтыг иш үндэс болгон дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр байгуулав.

1.2. Энэхүү гэрээний зорилго нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлыг дуусгах зорилгоор Гүйцэтгэгчийн олон улсын банк, санхүүгийн байгууллага болон бусад талуудаас босгосон хөрөнгийг нөхөн төлөхтэй холбогдон Талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулах, тэдгээрийн эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлоход оршино.

1.3. Энэхүү гэрээ нь "Тавантолгой төмөр зам" ХХК болон Гүйцэтгэгчийн хооронд 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдөр байгуулагдсан "Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээ" болон "Эрдэнэс-Тавантолгой" ХК, "Тавантолгой төмөр зам" ХХК, Гүйцэтгэгчийн хооронд 2019 оны 10 дугаар сарын 29 -ний өдөр байгуулагдсан "Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын санхүүжилтийн гэрээ"-ний нэгдмэл, салшгүй нэг хэсэг мөн болно.



ЭТТ Гүйцэтгэгч

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ

НУУЦ
CONFIDENTIAL

ИЛ БОЛСОН

## ХОЁРДУГААР ЗҮЙЛ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү гэрээнд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1. “Нүүрс” гэж органик гаралтай бодис геологийн урт хугацааны туршид газрын хэвлийд хуримтлагдан хувиралд орж үүссэн хурдас бөгөөд шатах органик цул ба үл шатах эрдэс хэсгээс тогтсон шатах ашигт малтмалыг;

2.2. “Коксжих нүүрс” гэж кокс үйлдвэрлэх боломжтой зөөлөн чулуун нүүрсийг /bituminous/;

2.3. “Талууд” гэж Худалдагч болон Гүйцэтгэгч нарыг, түүнчлэн Гүйцэтгэгчийн нэрлэсэн Худалдан авагч(ид) (цаашид “нэрлэсэн Худалдан авагч” гэх)-ийг хамтад нь;

2.4. “Гэрээт талбай” гэж Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт орших Тавантолгойн ордод хамаарах Худалдагчийн эзэмшлийн тусгай зөвшөөрлүүдийг хамарсан уурхайн талбай /цаашид “Тавантолгойн орд” гэх/-г;

2.5. “Олборлолт” гэж ил ба далд уурхайн арга, технологийн дагуу Уурхайн дэд бүтэц, Уурхайн техник, тоног төхөөрөмж ашиглан Уурхайн эдэлбэрээс Нүүрс ялган гаргах, ачиж тээвэрлэх, бутлах, дамжуулах зэрэг ажиллагааг;

2.6. ”Техник, эдийн засгийн үндэслэл” гэж Австралийн ”AECOM Australia” Pty Ltd компанийн 2013 оны 03 дугаар сарын 27-ны өдөр гүйцэтгэсэн Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн Техник, эдийн засгийн үндэслэл, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт /тодотгол/-ийг;

2.7. Энэхүү гэрээг тайлбарлахад мөн гэрээнд тусгайлан өөрөөр заагаагүй бол дараах дүрмийг баримтална:

2.7.1. гэрээний бүлэг, зүйлийг гэрээг хэрэглэхэд дөхөм болгох үүднээс гарчигласан бөгөөд ийнхүү гарчигласан нь гэрээний агуулгыг тайлбарлахад нөлөөлөхгүй;

2.7.2. гэрээнд өөрөөр тусгайлан заагаагүй бол гэрээнд заасан “зүйл”, “хэсэг”, “заалт”, “хавсралт” гэдэгт гэрээний зүйл, хэсэг, заалт, хавсралтыг ойлгоно.



ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ ХК
ЭТТ

Гүйцэтгэгч

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ

2.7.3. гэрээ болон бусад гэрээ, баримт бичигт дурдагдсан хувь хүн, хуулийн этгээд, байгууллагад тэдгээрийн хууль ёсны болон гэрээний дагуу эрхийг нь залгамжлан авах этгээдийг хамруулан ойлгоно;

CONFIDENTIAL

2.7.4. нэг тоогоор олон тоог, олон тоогоор нэг тоог төлөөлүүлэн хэрэглэж болно;

ИЛ БОЛСОН

2.7.5. “тухайлбал”, “жишээ нь”, “түүний дотор”, “хамааруулж”, “оролцуулан”, “гэх зэрэг”, “гэх мэт”, “зэрэг” гэж тодотгож үг орсон тохиолдолд зөвхөн тэр үгээр хязгаарлахгүй;

2.7.6. гэрээнд заасан хууль тогтоомж, дүрэм, журам, тушаал, захирамж, удирдамж, заавар, аргачлал болон бусад адилтгах баримт бичигт тэдгээрийн шинэчилсэн найруулга, тэдгээрт оруулсан нэмэлт өөрчлөлт, тэдгээрийг орлуулан баталсан хувилбарыг хамруулан ойлгоно;

2.7.7. гэрээнд заасан аливаа төлөвлөгөө, хөтөлбөр, тайлан, дүгнэлт, зөвлөмж, үнэлгээ, бүртгэл гэх зэрэг баримт бичигт тэдгээрт зохих ёсоор оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хамруулан ойлгоно;

2.7.8. гэрээнд өөрөөр тусгайлан заагаагүй бол нийтээр хүлээн зөвшөөрсөн техникийн болон худалдааны үг хэллэгийг нийтээр хүлээн зөвшөөрч хэрэглэдэг утгаар нь ойлгоно.

## ГУРАВДУГААР ЗҮЙЛ. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

3.1. Гүйцэтгэгч нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг дуусгахад шаардагдах 682,199,507 /зургаан зуун наян хоёр сая нэг зуун ерэн есөн мянга таван зуун долоо/ ам.доллар буюу энэхүү гэрээний 3.3-т заасны дагуу тодотгосон мөнгөн хөрөнгийг олон улсын банк, санхүүгийн байгууллага болон бусад талуудаас хөрөнгө босгох замаар санхүүжүүлнэ.

3.2. Худалдагч нь энэхүү гэрээний 3.1-д заасан санхүүжилтийг мөн гэрээгээр тохирсон нөхцөл, шаардлагын дагуу Гүйцэтгэгч буюу Гүйцэтгэгчийн нэрлэсэн Худалдан авагчид Гэрээт талбайгаас олборлосон нүүрс нийлүүлэх замаар нөхөн төлж барагдуулах бөгөөд Талууд нүүрс худалдах, худалдан авах гэрээг тусдаа байгуулна.

ЭТТ

Гүйцэтгэгч



ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

1930028

НУУЦ

3.3. Худалдагч нь энэхүү гэрээний 3.1-д заасан шаардагдах санхүүжилтийн дүнг Санхүүжилтийн гэрээний "Хавсралт Б"-д заасан аргачлалыг ашиглан тооцоолно.

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ" ХК

## ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

ИЛ БОЛСОН

4.1. Энэхүү гэрээ нь Талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн 5 /таван/ жилийн хугацаанд хүчинтэй.

4.2. Дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд Талууд гэрээний хугацааг сунгана:

4.2.1. Монгол Улс болон БНХАУ-ын төрийн эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэрийн улмаас хил гаалийн нэвтрүүлэх хүчин чадал багасч, гэрээний дагуу нийлүүлсэн буюу нийлүүлэх нүүрсийг экспортлох боломжгүй болсон;

4.2.2. гэрээний 17.1-д заасан давагдашгүй хүчин зүйл үүссэн;

4.2.3. гэрээний хугацааг сунгахаар Талууд зохих журмын дагуу харилцан тохиролцсон.

4.3. Энэхүү гэрээний 4.2.3-т заасан тохиолдолд Гүйцэтгэгч нь гэрээний хугацаа дуусахаас 60 /жар/ хоногоос доошгүй хугацааны өмнө сунгах хүсэлтээ бичгээр ирүүлэх ба Талууд харилцан тохиролцож гэрээний хугацааг сунгаж болно. Гүйцэтгэгч гэрээний хугацаа сунгах талаар хүсэлтээ бичгээр мэдэгдсэн нь Худалдагч гэрээний хугацааг зайлшгүй сунгах үүрэг хүлээх үндэслэл болохгүй.

## ТАВДУГААР ЗҮЙЛ. НҮҮРСНИЙ ҮНЭ БА ҮНИЙН ИНДЕКС

5.1. Худалдагч нь энэхүү гэрээний дагуу FCA-уурхайн ам нөхцөлөөр нийлүүлэх 3, 4 дүгээр давхаргын коксжих нүүрсний анхны суурь үнэ нэг тонн нь 60.0 /жар/ ам.доллар байна. FCA нөхцөлийг олон улсын худалдааны 2010 оны нөхцөл (INCOTERMS 2010)-д заасны дагуу ойлгоно.

5.2. Худалдагч болон Гүйцэтгэгч харилцан тохиролцвол 5.1-д зааснаас бусад давхаргын коксжих нүүрс, исэлдсэн /эрчим хүчний/ нүүрс болон угааж баяжуулсан коксжих нүүрс худалдан авч болох бөгөөд нүүрсний үнэ, хэмжээг тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулан Талууд тусдаа гэрээгээр харилцан тохиролцож тогтооно.



ЭТТ

Гүйцэтгэгч

ЭТТ-ШИПЭН КОМПАНИ

1930029

НУУЦ

5.3. Гэрээний 5.1-д заасан үнэд нүүрсийг олборлох, шилжүүлэн ачих төлбөр, Монгол Улсын бүх төрлийн татвар, хураамж, Монгол Улсад гарах бусад зардал, Гүйцэтгэгчээс Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам барихад зориулан олон улсын банк, санхүүгийн байгууллага, бусад талуудаас хөрөнгө босгоход гаргасан бүх зардал багтана.

CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ" ХК

5.4. Энэхүү гэрээгээр тохиролцсон суурь үнэ нь нүүрсийг зөвхөн Гашуунсухайт-Ганцмод боомтоор экспортолсон тохиолдолд хүчинтэй ба өөр боомтоор экспортолсон тохиолдолд Талууд суурь үнийг шинээр тохиролцоно.

ИЛ БОЛСОН

5.5. Гэрээний 5.1-д заасан суурь үнээс дараах аргачлалын дагуу нүүрсний үнийг улирал тутам шинэчлэн тогтооно. Үүнд:

Үнийн индекс: Бүтээгдэхүүний үнийг индексжүүлэх бөгөөд тухайн бүтээгдэхүүний үнийг жил бүрийн 01 дүгээр сарын 01, 04 дүгээр сарын 01, 07 дугаар сарын 01, 10 дугаар сарын 01-ний өдөр эхлэх улирал тутам өөрчлөн тогтоож, тухайн улирлыг дуустал мөрдөнө. Улирал тутмын индекс ба үнийг тооцоолох аргачлалыг гэрээний "Хавсралт Б"-д тодорхойлно.

Нүүрсний үнийн индексийн сагс нь дараах индексүүдээс бүрдэнэ. Үүнд: i) http://en.sxcoal.com веб хуудаст мэдээлэгдэх CR China Coking Coal Price Index (жин 30%), ii) http://www.metalbulletin.com веб хуудаст мэдээлэгдэх Metal Bulletin Coking Coal Index, Hard Coking Coal CFR Jingtang USD per tonne (жин 20%), iii) Platts Coal Trader International тайланд нийтлэгдэх Platts Hard Coking Coal 64 Mid Vol CFR China Daily Spot Price ( жин 10%), iv) http://en.sxcoal.com веб хуудаст мэдээлэгдэх Shanxi Liulin Seam 4 Unwashed Clean Hard Coking Coal Price (жин 10%), v) http://en.sxcoal.com веб хуудаст мэдээлэгдэх Production areas Primary Coking Average (жин 30%).

5.6. Гэрээний 5.5-д заасан Нүүрсний үнийн индексийн сагсын аль нэг индекс нь нийтлэгдэхээ больсон тохиолдолд аль нэг тал нь санал гаргаж, Талууд тохирох индексээр 30 /гуч/ хоногийн дотор харилцан тохиролцоно. Энэ тохиолдолд Талууд энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна.

5.7. Хэрэв Худалдагч болон Гүйцэтгэгч харилцан тохиролцвол энэхүү гэрээний 5.6-д заасан нүүрсний үнийн индекс (аль нэгийг, эсхүл бүхэлд нь)-ийг өөр индексээр сольж болно. Энэ тохиолдолд Талууд энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна.

ЭТТ | Гүйцэтгэгч



ЭТТ-ШИПЭН КОМПАНИ

1930030

НУУЦ

5.8. Гүйцэтгэгч буюу Гүйцэтгэгч талын нэрлэсэн Худалдан авагч нь энэхүү гэрээний дагуу хүлээн авсан нүүрсийг БНХАУ-ын Ганцмод боомтод худалдан борлуулах тохиолдолд Худалдагчийн бусад худалдан авагчид борлуулж байгаа үнээс хямд үнээр худалдан борлуулахгүй байх үүрэгтэй бөгөөд худалдах тохиолдолд холбогдох мэдээллийг 14 /арван дөрөв/ хоногийн өмнө Худалдагчид урьдчилан мэдэгдэнэ. Энэ нь Гүйцэтгэгч буюу Гүйцэтгэгч талын нэрлэсэн Худалдан авагч нүүрсийг Ганцмод боомтод хадгалах, дамжуулан ачих, тээвэрлэхэд хамаарахгүй.

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС-ТАВАН ТОЛГОЙ" ХК
ИЛ БОЛСОН

## ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. НҮҮРСНИЙ ГАРАЛ ҮҮСЭЛ БОЛОН ЧАНАР

6.1. Энэхүү Гэрээний дагуу нийлүүлэх нүүрс нь Монгол Улсын Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгойн ордоос олборлосон нүүрс байна.

6.2. Энэхүү гэрээний 6.1-д заасан нүүрсний чанарын үзүүлэлтийг гэрээний "Хавсралт В"-д заасан болно.

6.3. Талууд нийлүүлэх нүүрснээс дээж авах, дээжийг бэлтгэх, дээжийн чанарын шинжилгээг дараах байдлаар хамтран гүйцэтгэнэ:

6.3.1.Талуудын төлөөллийг байлцуулан ачигдаж буй нүүрснээс 30,000 /гучин мянган/ тонн тутам нэг удаа дээж авна. Дээжийн чанарыг шинжлэхдээ ISO стандартыг мөрдөнө;

6.3.2.Гуравдагч дээжийг агаараас тусгаарлан битүүмжилж, дээж авсан өдрөөс хойш 30 /гуч/ хоногийн турш хадгална;

6.3.3.Талууд нь нүүрсний чанарын шинжилгээг тус тусын лабораторид хийж гүйцэтгэх бөгөөд холбогдох зардлыг өөрсдөө хариуцна;

6.3.4.Талуудын хооронд нийлүүлсэн нүүрсний чанарын талаар маргаан гарвал Гүйцэтгэгч буюу Гүйцэтгэгч талын нэрлэсэн Худалдан авагч нь ажлын 3 /гурав/ хоногийн өмнө мэдэгдэж нүүрсний ачилтыг түр хугацаанд зогсоох ба талууд хамтран гуравдагч дээжийг авч, нүүрсний чанарын шинжилгээг талуудын сонгосон, магадлан итгэмжлэгдсэн хөндлөнгийн лабораторид хийлгэх бөгөөд шинжилгээний үр дүнгээр маргааныг эцэслэн шийдвэрлэнэ;

ЭТТ Гүйцэтгэгч



ЭТТ-ШИПЭН КОМПАНИ

1930031

НУУЦ

6.3.5.Гуравдагч дээжийн чанарыг хөндлөнгийн лабораторид шинжлүүлэхтэй холбогдон гарах зардлыг Талууд тэнцүү хэмжээгээр хамтран хариуцна.

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ" ХК

6.4. Хөндлөнгийн лабораторийн шинжилгээний дүнг харгалзан энэ гэрээний "Хавсралт В"-д заасан чанарын шаардлага хангасан нүүрсийг дараа сард багтаан Гүйцэтгэгчид нөхөн нийлүүлнэ.

ИЛ БОЛСОН

6.5. Худалдагч нь энэхүү гэрээний 6.4-т заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд мөн гэрээний 19.4-т заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## ДОЛООДУГААР ЗҮЙЛ. НИЙЛҮҮЛЭХ НҮҮРСНИЙ ТОО ХЭМЖЭЭ, НҮҮРС НИЙЛҮҮЛЖ ЭХЛЭХ ХУГАЦАА БА ТООЦОО НИЙЛЭХ

7.1. Гэрээний дагуу Худалдагчаас жил бүр Гүйцэтгэгч буюу Гүйцэтгэгчийн нэрлэсэн Худалдан авагчид нийлүүлэх нүүрсний нийт мөнгөн дүн тэнцүү байх ба Худалдагчаас гэрээний хугацаанд Гүйцэтгэгч буюу Гүйцэтгэгчийн нэрлэсэн Худалдан авагчид нийлүүлэхээр хэлэлцэн тохиролцсон нүүрсний хэмжээ, хуваарийг гэрээний "Хавсралт А"-аар баталгаажуулж, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Гүйцэтгэгч буюу Гүйцэтгэгчийн нэрлэсэн Худалдан авагчид нийлүүлнэ. Нүүрс нийлүүлэх хэмжүүр нь тонн байна.

Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний дагуу нийлүүлэх нүүрсийг хүлээн авах нэрлэсэн Худалдан авагчийн талаарх мэдээллийг тухайн нүүрсийг нийлүүлэхээс 14 /арван дөрөв/ хоногийн өмнө Худалдагчид мэдэгдэнэ.

7.2. Гэрээний 5.5-д заасны дагуу нүүрсний үнийг индексжүүлэхтэй холбогдуулан улирал тутам нийлүүлэх нүүрсний төлөвлөгөөг шинэчлэх бөгөөд нүүрсний үнийг өөрчлөн тогтоосноос хойш 3 /гурван/ хоногийн дотор Талууд гэрээний "Хавсралт А"-д заасан нүүрс нийлүүлэх төлөвлөгөөнд өөрчлөлт оруулна.

7.3. Худалдагчийн энэхүү гэрээний "Хавсралт А"-д заасан хуваарийн дагуу нийлүүлэх нүүрс нь 3, 4 давхаргаас тэнцүү хэмжээтэй байх бөгөөд нүүрсийг сорчлон ашиглахгүй байх зорилгоор бусад давхаргын коксжих нүүрс, исэлдсэн /эрчим хүчний/ нүүрс болон угааж баяжуулсан коксжих нүүрсийг энэхүү гэрээний 5.2-т заасны дагуу нийлүүлнэ.

7.4. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас хэлэлцэн тохирсон хувь хэмжээний нүүрсийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хүлээн авах боломжгүй болсон

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ



ЭТТ      Гүйцэтгэгч

TAVAN TOLGOI ERDENES ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ ХК УЛААНБААТАР ХОТ JSC
БОДЬ ИНТЕРНЭШНЛ ХХК TTA1515

НУУЦ

бол Гүйцэтгэгч буюу Гүйцэтгэгчийн нэрлэсэн Худалдан авагчид нийлүүлэх ёстой байсан нүүрсийг дараагийн сард нөхөн нийлүүлнэ. Нөхөн нийлүүлсэн нүүрсний үнийг тухайн нүүрсийг нийлүүлэх ёстой байсан улирлын үнээр тооцно.

НУУЦ CONFIDENTIAL "ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ" ХК

7.5. Талууд нь гэрээний дагуу нийлүүлсэн буюу хүлээн авсан нүүрсний тооцоог сар бүрийн дараа сарын 15-ны өдөрт багтаан нийлнэ.

ИЛ БОЛСОН

7.6. Гүйцэтгэгч нь тооцоо нийлэх мэдэгдлийг энэхүү гэрээний 7.5-д заасан хугацаанаас 5 /тав/ хоногийн өмнө Худалдагчид хүргүүлнэ. Тооцоо нийлэх мэдэгдэлд дараах зүйлсийг тусгана:

7.6.1. энэхүү гэрээний дагуу тухайн сард хүлээн авах ёстой нүүрсний хэмжээ болон бодитоор хүлээн авсан нүүрсний хэмжээ;

7.6.2. нүүрсний үнэ.

7.7. Хэрэв тухайн сард нийлүүлсэн нүүрсний бодит хэмжээ, үнийн талаар зөрүү гарвал Худалдагч болон Гүйцэтгэгч нь нийлүүлэлтийн хэмжээг тооцсон аргачлал, холбогдох баримтыг ашиглан зөрүүг нягталж Талууд протокол үйлдэн баталгаажуулна. Тооцоо нийлэх мэдэгдлийн маягтыг Талууд хамтран батална.

7.8. Энэхүү гэрээний 6.3.4, 17 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд Гүйцэтгэгч нь нийлүүлэлтийн төлөвлөгөөнд заагдсан нүүрсийг 3 /гурван/ сар дараалан татаж аваагүй тохиолдолд Худалдагч нь тухайн нүүрсийг нөхөж нийлүүлэх үүргээсээ чөлөөлөгдөнө.

## НАЙМДУГААР ЗҮЙЛ. НҮҮРС НИЙЛҮҮЛЭХ ЦЭГ

8.1. Худалдагч нь гэрээний дагуу Гүйцэтгэгчид нүүрс нийлүүлэх цэг нь Уурхайн ам байх ба Гүйцэтгэгч буюу Гүйцэтгэгчийн нэрлэсэн Худалдан авагчийн тээврийн хэрэгсэлд нүүрсийг Уурхайн амнаас ачиж өгснөөр нүүрсний өмчлөх эрх, холбогдох бүхий л зардал, үр ашиг болон эрсдэл Гүйцэтгэгч буюу Гүйцэтгэгчийн нэрлэсэн Худалдан авагчид бүрэн шилжинэ.

## ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. ЖИН ХЭМЖЭЭ

9.1. Нүүрсний жинг ачаатай болон ачаагүй тээврийн хэрэгслийн жингийн зөрүүгээр тодорхойлно. Нүүрс нийлүүлэх цэг дэх ачигдсан жин нь эцсийн бөгөөд албан ёсны байна.



ЭТТ Гүйцэтгэгч

ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ ХК JSC

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ" ХК
НУУЦ
ИЛ БОЛСОН

9.2. **Авто жингийн буюу ачилтын бичиг баримтууд:** Нүүрс ачих цэгт Худалдагчийн холбогдох ажилтан тээврийн хэрэгслийн бүртгэлийн дугаар, нүүрстэй болон нүүрсгүй байх үеийн жин, ачилтын огноо, хүргэх цэг зэрэг мэдээллийг агуулсан авто жингийн бичиг баримтыг үйлдэнэ. Авто жингийн бичиг баримтад Худалдагч болон Гүйцэтгэгч буюу Гүйцэтгэгчийн нэрлэсэн Худалдан авагчийн эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурах бөгөөд тус бүр нэг хувийг хадгална. Худалдагч нь ачилт эхлэхээс өмнө Монгол Улсын Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвөөс олгосон пүүний баталгаажуулалтын сертификатын хуулбарыг Гүйцэтгэгч буюу Гүйцэтгэгчийн нэрлэсэн Худалдан авагчид хүлээлгэн өгнө.

9.3. Нүүрс нийлүүлэх цэг дэх нүүрсний жин, хэмжээ болон чанарын үзүүлэлт нь эцсийнх бөгөөд Талуудын хүлээн зөвшөөрсөн үр дүн байна. Гүйцэтгэгч нь нүүрсийг Монгол улсын аль ч гаалийн хяналтын талбайгаар дамжин экспортлох үеийн нүүрсний хэмжээ, чанарт гарах аливаа өөрчлөлтийг хариуцна.

9.4. Гүйцэтгэгч буюу Гүйцэтгэгчийн нэрлэсэн Худалдан авагч нь шаардлагатай тохиолдолд Худалдагч болон холбогдох төрийн эрх бүхий байгууллагын төлөөлөгчийн оролцоотойгоор нүүрс жигнэх хэрэгслийг шалгах ажлыг зохион байгуулж болно.

## АРАВДУГААР ЗҮЙЛ. АЧИЛТЫН ХУВААРЬ

10.1. Нүүрс ачилтын хуваарийг Гүйцэтгэгчийн саналыг үндэслэн харилцан тохиролцсоны үндсэн дээр тогтоох ба Худалдагч нь энэхүү гэрээгээр тохирсон хэмжээний нүүрсийг тогтоосон хуваарийн дагуу ачих зорилгоор Тавантолгойн уурхайд ачилтын тусгай гарц талбай байгуулж, хамтран ажиллана.

10.2. Гүйцэтгэгч буюу Гүйцэтгэгчийн нэрлэсэн Худалдан авагч нь нүүрсийг гэрээний 10.1-д заасан хуваарийн дагуу тээвэрлэнэ.

## АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. ТЭЭВЭР

11.1. Гүйцэтгэгч буюу Гүйцэтгэгчийн нэрлэсэн Худалдан авагч нь нүүрс тээвэрлэх тээврийн хэрэгслийг зохион байгуулж, төлбөрийг хариуцах ба тээвэрлэгч компаниудын талаарх албан ёсны мэдээллийг Худалдагчид тээвэрлэлт эхлэхээс 3 /гурав/ хоногоос доошгүй хугацааны өмнө хүргүүлнэ.

ЭТТ



Гүйцэтгэгч

ЭТТ-ШИПЭН КОМПАНИ
1930034

НУУЦ

11.2. Гүйцэтгэгч буюу Гүйцэтгэгчийн нэрлэсэн Худалдан авагч нь "Тээврийн хариуцлагын гэрээ" байгуулсан тээвэрлэгч компанийг сонгон ажиллана. Нүүрсний тээвэрлэлтийг Монгол өмчлөгчтэй Монгол Улсын тээврийн компаниар гүйцэтгүүлэхээр хичээн ажиллах болно.

CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ" ХК

11.3. Гүйцэтгэгч буюу Гүйцэтгэгчийн нэрлэсэн Худалдан авагч нь тээвэрлэгч компанитай байгуулах "Тээврийн гэрээ"-нд тухайн тээвэрлэгч компанийн сар бүрийн ачилтын хуваарийг дэлгэрэнгүй тусгаж өгөх бөгөөд нийт тээвэрлэлт гүйцэтгүүлэх тээврийн хэрэгслийн тоог энэхүү гэрээний дагуу худалдан авах нийт нүүрсний хэмжээнд уялдуулна.

ИЛ БОЛСОН

11.4. Худалдагч нь гэрээнд заасан ачилтын хуваарийн гүйцэтгэлийг хангахын тулд Гүйцэтгэгч буюу Гүйцэтгэгчийн нэрлэсэн Худалдан авагчийн гэрээт тээврийн хэрэгслүүдийг Уурхайн ачилтын бүртгэлд бүртгүүлэн, уурхайн нүүрс ачилтын үйл ажиллагаанд хамруулна. Гүйцэтгэгч буюу Гүйцэтгэгчийн нэрлэсэн Худалдан авагч нь гаалийн хяналтын талбайгаар дамжин нүүрс экспортлох тээврийн хэрэгслийн талаарх шаардлагатай бүхий л мэдээллийг Худалдагчид урьдчилан хүргүүлнэ.

11.5. Гүйцэтгэгч болон Гүйцэтгэгчийн нэрлэсэн Худалдан авагч нь тээвэрлэгч компанитай байгуулсан "Тээврийн гэрээ"-ний хүрээнд тээврийн хэрэгслийн жолооч нарын нийгмийн асуудлыг хариуцаж, хянаж ажиллах үүрэг хүлээсэн байна.

11.6. Энэхүү Гэрээнд заасан нүүрсний үнэд нүүрс хучилтын зардал болон тээвэртэй холбоотой бусад зардлууд багтаагүй болно. Нүүрс хучилтын үйлчилгээг Худалдагч нь Гүйцэтгэгчтэй, эсхүл Гүйцэтгэгчийн нэрлэсэн худалдан авагч компанитай байгуулсан тусдаа гэрээгээр зохицуулж, төлбөрийг сар бүр Гүйцэтгэгч талаас нэхэмжилнэ.

## АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ. ТАТВАР

12.1. **Худалдагчийн хариуцах татвар**: Монгол Улсад төлөгдөх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, НӨАТ болон уурхайн үйл ажиллагаатай холбогдсон бүх татвар, хураамж, төлбөр /Нүүрс экспортлоход шаардлагатай Уул Уурхайн Үндэсний Хүрээлэнгийн дүгнэлтийн төлбөр, Гаалийн Төв Лабораторийн дүгнэлтийн төлбөр, Гаалийн хураамж, Манифестийн хураамж, Лац, Гаалийн мэргэжлийн хяналт, хорио цээрийн хяналтын хураамж, Гарал үүслийн гэрчилгээний хураамж/-ийг хариуцна.



ЭТТ

Гүйцэтгэгч

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ

12.2. **Гүйцэтгэгч болон Гүйцэтгэгчийн нэрлэсэн Худалдан авагчийн хариуцах татвар:** Нүүрс импортлохтой холбоотой БНХАУ-д ногдуулж буй холбогдох бүх татвар, хураамж тухайлбал, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, орон нутгийн татвар хураамжууд, импортын татвар болон бусад хураамж зэргийг хариуцна.

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ" ХК

**АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ БОЛОН БАЙГАЛЬ ОРЧИН**

ИЛ БОЛСОН

13.1. Худалдагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчинтой холбоотой хууль, дүрэм, журам түүнд нийцүүлэн гаргасан эрх бүхий этгээдийн тушаал, шийдвэр, дүрэм, журмыг дагаж мөрдөх бөгөөд өөрийн болон бусад туслан гүйцэтгэгч, гэрээт компанийн ажилтнуудад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг танилцуулах, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулж, зааварчилгаа өгсөн байх үүрэгтэй.

13.2. Худалдагч нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд зааснь дагуу өөрийн гэрээт болон туслан гүйцэтгэгч компаниудтай хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг хамтын ажиллагааны гэрээнд тодорхой тусгаж оруулсан байх үүрэгтэй.

13.3. Худалдагч нь Гүйцэтгэгчийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон байгаль орчны асуудлаар үүсч болох бүх төрлийн хариуцлага, нэхэмжлэл, шаардлага, алдагдал, үүрэг, зардлаас (хуульчдын бодит ажлын хөлс ба мөрдөн шалгах болон маргааныг шүүхийн журмаар шийдвэрлэхтэй холбогдон үүссэн бусад зардал) ангид байлгах үүрэгтэй.

13.4. Гүйцэтгэгч буюу Гүйцэтгэгчийн нэрлэсэн Худалдан авагч нь өөрийн болон гэрээт, туслан гүйцэтгэгч компаниудын тээврийн хэрэгсэл болон жолооч нарыг тээврийн хэрэгслийн, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд, мөн өөрийн ажилтнуудын амь нас, эрүүл мэндийг зохих даатгалд даатгуулсан байх ба тэдгээр ажилтнууд нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон замын хөдөлгөөний дүрмийг мөрдөж ажиллана.

13.5. Гүйцэтгэгч буюу Гүйцэтгэгчийн нэрлэсэн Худалдан авагч болон түүний гэрээт компаниудын жолоочид нүүрс тээврийн замд жолоо барьж байх үедээ бүх төрлийн согтууруулах ундаа, мансууруулах бодис, тайвшруулах үйлчилгээтэй эм хэрэглэх мөн Худалдагчийн эрх бүхий ажилтан болон хамгаалагчийн шаардлагыг



ЭТТ                                                            Гүйцэтгэгч

ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ ХК
БОДЬ ИНТЕРНЭШНЛ ХХК
ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ
1930036

НУУЦ

биелүүлэхээс татгалзах, хэл амаар доромжлох, зүй бусаар харьцах, танхайрахыг хатуу хориглоно.

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ" ХК
ИЛ БОЛСОН

## АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. МЭДЭГДЭЛ, БАТАЛГАА

14.1. Талууд нь Санхүүжилтийн гэрээний 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл, баталгааг энэхүү гэрээгээр мөрдөнө.

## АРВАН ТАВДУГААР ЗҮЙЛ. НУУЦЛАЛ

15.1. Энэхүү гэрээний нөхцөл, заалт нь нууц байх бөгөөд хуулийн дагуу төрийн эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд Талуудын бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд задруулахгүй.

## АРВАН ЗУРГАДУГААР ЗҮЙЛ. ГЭРЭЭГЭЭР ХҮЛЭЭСЭН ЭРХ, ҮҮРЭГ БОЛОН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИЛЖҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОХ

16.1. Талууд нь энэхүү гэрээний дагуу хүлээсэн эрх, үүргээ нөгөө талын бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

## АРВАН ДОЛООДУГААР ЗҮЙЛ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

17.1. Давагдашгүй хүчин зүйл гэж Талуудын санаатай буюу болгоомжгүй буруутай үйлдэл, эс үйлдэхүйгээс үл хамаарах, түүнийг урьдчилан мэдээгүй буюу мэдэх боломжгүй байсан бөгөөд түүнийг даван туулах, эсхүл зайлуулах буюу үр дагаврыг нь бууруулах боломжгүйгээс гэрээний үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон дараах нөхцөл байдлыг ойлгоно:

17.1.1.үер, газар хөдлөлт, хөрсний гулгалт, гал түймэр, хүчтэй шуурга, аадар бороо, эрс хүйтрэлт, цаг агаарын гэнэтийн ноцтой үзэгдэл зэрэг байгалийн гамшигт нөхцөл байдал;

17.1.2.тахал, халдварт өвчин буюу хорио цээр, түүнчлэн гадаад улсын болон дотоодын төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр хил, авто болон төмөр замын харилцааг хаах, эсхүл түр зогсоох, импорт, экспортын хориг, хязгаарлалт тавьсан;

17.1.3.дайн, түрэмгийлэл, зэвсэгт мөргөлдөөн болон гадны халдлага, бүслэлт, худалдааны хориг, хувьсгал;

TAVAN TOLGOI ERDENES ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ ХК УЛААНБААТАР ХОТ JSC

ЭТТ



Гүйцэтгэгч

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ" ХК
ИЛ БОЛСОН

17.1.4.улс даяар өрнөсөн, эсхүл салбар, Талуудын үйл ажиллагааг хамарсан ажил хаялт, улс төрийн жагсаал, цуглаан, бослого.

17.2. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ бүхэлд нь буюу хэсэгчлэн биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлж чадаагүйгээс үүссэн үр дагаврыг Талууд хариуцахгүй. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлж чадаагүй нөхцөл байдлыг гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн гэж үзэхгүй бөгөөд түүний үргэлжлэх хугацаанд тухайн үүргийн гүйцэтгэл болон цаг хугацааны шаардлагыг түр зогссон гэж үзнэ.

17.3. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй болсон тал нь энэ тухай болон түүний шалтгааны талаар уг хүчин зүйл бий болсон хугацаанаас хойш 3 /гурав/ хоногийн дотор нөгөө талдаа бичгээр шуурхай мэдэгдэх бөгөөд Талууд шалтгааныг арилгах боломжтой бүхий л арга хэмжээг авахын зэрэгцээ түүнийг арилгахын төлөө хамтран ажиллана. Мэдэгдэлд дараахь мэдээллийг заавал тусгана:

17.3.1.шинж чанар, нөлөөлөл, хамрах хүрээний талаархи нотлох баримт бүхий мэдээлэл;

17.3.2.үргэлжлэх хугацаа, эсхүл энэ талаархи таамаг;

17.3.3.гэрээгээр хүлээсэн үүргийн гүйцэтгэлд саад учруулах, эсхүл саад учруулж болзошгүй нөлөөллийн талаархи таамаг;

17.3.4.давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөл, учруулах хохирлын хэмжээг багасгах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа, эсхүл авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа арга хэмжээ;

17.3.5.холбогдох бусад мэдээлэл.

17.4. Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөх цар хүрээнээс илүү хэмжээгээр буюу түүний үргэлжлэх хугацаанаас урт хугацаагаар гэрээгээр хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хойшлуулахгүй.

17.5. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас учирсан зардлыг Талууд тус бүр өөрсдөө хариуцна.

ЭТТ

Гүйцэтгэгч



ЭТТ-ШИПЭН КОМПАНИ

1930038

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
НУУЦ
ИЛ БОЛСОН

17.6. Гэрээний аль нэг тал нь давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ бүхэлд нь буюу хэсэгчлэн биелүүлээгүй, эсхүл хойшлуулсан тохиолдолд тухайн давагдашгүй хүчин зүйлийн үр дагаврыг арилгахад бодитойгоор шаардагдах боломжит хугацаа болон тухайн ажлыг эхлүүлэх буюу үргэлжлүүлэхэд шаардагдах бэлтгэл ажлын боломжит хугацааг энэхүү гэрээнд уг ажлыг гүйцэтгэхээр заасан буюу бусад хэлбэрээр зөвшөөрсөн хугацаан дээр нэмж тооцохын зэрэгцээ гэрээний хугацааг уг хугацаагаар сунгана.

## АРВАН НАЙМДУГААР ЗҮЙЛ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

18.1. Гэрээнээс үүдэлтэй буюу түүнтэй холбоотойгоор Талуудын хооронд аливаа маргаан гарвал түүнийг эхний ээлжинд хэлэлцэн тохиролцож шийдвэрлэх бөгөөд аль нэг тал нь хэлэлцээ хийх хүсэлтийг бичгээр тавьснаас хойш ажлын 30 /гуч/ хоног, эсхүл харилцан тохиролцсон түүнээс дээш, тодорхой хугацааны дотор Талууд нэгдсэн шийдвэрт хүрч чадаагүй бол хуульд өөрөөр заагаагүй бол уг маргааныг энэхүү гэрээний 18.2-т заасны дагуу шийдвэрлэнэ.

18.2. Талууд маргаанаа энэхүү гэрээний 18.1-д заасны дагуу шийдвэрлэж чадаагүй бол уг маргааныг МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон улсын ба Үндэсний арбитрт хандаж шийдвэрлүүлнэ.

18.3. Арбитрчдын тоо 3 /гурав/ байна. Арбитрын шүүх ажиллагааг Монголын Олон улсын ба Үндэсний арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу явуулна.

18.4. Арбитрын шийдвэр эцсийнх байх бөгөөд уг шийдвэрийг Талууд заавал биелүүлнэ.

## АРВАН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. ТОРГУУЛЬ, ХАРИУЦЛАГА

19.1. Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол нөгөө талдаа учирсан шууд хохирлыг энэхүү гэрээнд заасны дагуу хариуцан арилгана.

19.2. Худалдагч нь хууль болон энэхүү гэрээнд заасанаас бусад үндэслэлээр гэрээг хугацаанаас өмнө цуцалсан, нүүрс нийлүүлэхээ зогсоосон тохиолдолд гэрээг цуцлах, зогсоох хүртэлх хугацаанд Гүйцэтгэгчийн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээнд заасны дагуу гүйцэтгэсэн ажилд зарцуулсан хөрөнгийн 20 /хорь/ хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийн торгуулийг Гүйцэтгэгчид төлнө.



ЭТТ — Гүйцэтгэгч

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ

CONFIDENTIAL

"ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ" ХК

19.3. Энэхүү гэрээний 20.2-д заасны дагуу Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалж гэрээ цуцлагдсан тохиолдолд Худалдагчаас Гүйцэтгэгчид нийлүүлсэн нийт нүүрсний үнийн дүнгийн 20 /хорь/ хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийн торгуулийг Гүйцэтгэгч төлнө.

19.4. Энэхүү гэрээний 6.3.4, 17 дугаар зүйлд заасныаас бусад тохиолдолд Худалдагч нь энэхүү гэрээний "Хавсралт А"-д заасан хуваарийн дагуу нүүрс нийлүүлээгүй тохиолдолд нийлүүлэх ёстой байсан нүүрсний төлбөрт мөнгөн дүнгээр тооцож сарын 1 /нэг/ хувийн хүү тооцно. Хүүг хоног тутам, сарын 30 /гуч/ хоногоор тооцож бодно. Хүү тооцох нүүрсний үнийг гэрээний 5.1, 5.5-д заасны дагуу тогтооно.

## ХОРЬДУГААР ЗҮЙЛ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

20.1. Энэхүү Гэрээ нь дараахь тохиолдолд дуусгавар болно. Үүнд:

20.1.1.Энэхүү гэрээний 4.1-д хүчинтэй хугацаа дуусгавар болсон бөгөөд Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн;

20.1.2."Тавантолгой төмөр зам" ХХК болон Гүйцэтгэгчийн хооронд 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдөр байгуулагдсан Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээ болон "Эрдэнэс-Тавантолгой" ХК, "Тавантолгой төмөр зам" ХХК, Гүйцэтгэгчийн хооронд 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдөр байгуулагдсан Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын санхүүжилтийн гэрээ хүчингүй болсон;

20.1.3.Худалдагч нь Гүйцэтгэгчийн бичгээр гаргасан зөвшөөрөлгүй энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ бусад этгээдэд шилжүүлсэн бөгөөд үүнтэй холбогдуулан гэрээг дуусгавар болгох тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчээс Худалдагчид хүргүүлсэн бол;

20.1.4.Талууд гэрээг дуусгавар болгох тухай хүсэлт гаргасны дагуу харилцан тохиролцсон бол;

20.1.5.энэхүү гэрээнд заасан тохиолдол үүссэн бол.



ЭТТ

Гүйцэтгэгч

1930040

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ" ХК
ИЛ БОЛСОН

20.2. Дараахь тохиолдолд Худалдагчийн санаачилгаар энэхүү гэрээг цуцалж, дуусгавар болгоно. Үүнд:

